



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРОЛЦОХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛЭХ УРИЛГА

Огноо: 2024 оны 10 дугаар сарын 08

Монгол Улс

Төслийн нэр: Ухаалаг засаг-2 төсөл

Төслийн дугаар: P176631

Даалгаврын нэр: “Цахим шилжилтийн талаар хууль, тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах” зөвлөх үйлчилгээ

### Дугаар: 1.1.2

Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжиж буй "Ухаалаг засаг-2" төсөл нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэх төрийн цахим үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх, цахим ур чадвар болон дижитал технологид суурилсан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь дор дурдсан шаардлагуудыг хангасан зөвлөх компаниудыг зөвлөх үйлчилгээ үзүүлэх сонирхлоо илэрхийлэхийг урьж байна.

**Зөвлөх фирмийн ерөнхий шаардлага, чадварын тухайд:** Гүйцэтгэгч байгууллага нь Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн зөвлөхийн ажлыг зарласан өдрөөс хойших хугацааны байдлаар бүрэн төлсөн, мөн дараах лавлагаа, тодорхойлолтуудыг ирүүлсэн байна:

1. Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ.
2. Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татварын өр төлбөргүй байх шаардлагатай. Цахим татварын систем эсвэл e-Mongolia-с авсан QR код бүхий лавлагаа ирүүлнэ.
3. Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай. Нийгмийн даатгалын систем эсвэл e-Mongolia-с авсан QR код бүхий лавлагаа ирүүлнэ.
4. Монгол Улсын хуулийн этгээд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.

**Санхүүгийн шалгуур үзүүлэлт:** Тендерт оролцогч одоогийн санхүүгийн байдлаа харуулсан Сүүлийн 2 (хоёр) жилийн аудитын тайлан (2022 ба 2023 онууд хамаарна) ирүүлэх хэрэгтэй.

Борлуулалтын хэмжээ: 2022,2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх шаардлагатай ба үүнийг нотлох санхүүгийн тайлан ирүүлэх;

**Чадварын шалгуур үзүүлэлт:** Зөвлөх нь дараах мэргэшил, туршлагатай зөвлөх фирм эсвэл хуулийн болон PR фирмийн түншлэл байж болно. Зөвлөх нь олон нийттэй харилцах, хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр дотоодын туршлагыг тэнцвэртэй хослуулсан байх ёстой. Зөвлөхийн мэргэшил, туршлагад тавигдах шаардлага нь дараах байдалтай байна.

### 1. Олон нийттэй харилцах чиглэлээр дотоодын туршлага:

- Монгол Улсын хэмжээнд олон нийттэй харилцах чиглэлээр батлагдсан туршлагатай (хамгийн багадаа 3 жил) олон нийттэй харилцах, хэвлэл мэдээлэлтэй харилцах, сурталчлан таниулах кампанит ажлаар мэргэшсэн зөвлөх компани болон хувь хүмүүс байх.
- Олон нийттэй харилцах стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр туршлага хуримтлуулсан, ялангуяа төрийн болон олон нийтийн төслүүдэд зөвлөх

үйлчилгээ үзүүлж байсан, эдгээр төслүүд нь Монгол Улсад хэрэгжиж байсан бол давуу талтай гэж үзнэ.

- Дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй ажил хэргийн нягт харилцаа холбоотой, Монголын нөхцөлд олон нийтийн аян/кампанит ажлыг өмнө нь үр дүнтэй хэрэгжүүлж байсан батлагдсан туршлагатай.

## 2. Цахим хөгжлийг дэмжсэн багц хуулиудад төвлөрсөн хууль эрх зүйн туршлага:

- Цахим хөгжлийг дэмжсэн багц хууль тогтоомж, цахим засаглал эсвэл холбогдох чиглэлээр мэргэшсэн, хуулийн салбарт холбогдох туршлагатай (хамгийн багадаа 3 жил)
- Монгол Улсын хууль эрх зүйн тогтолцооны талаар хангалттай мэдлэгтэй, цахим шилжилт, кибер аюулгүй байдалтай холбоотой хууль эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгч байсан туршлагатай.

## 3. Мэдээлэл, харилцаа холбоо болон хуулийн хосолмол чадавх:

- Монгол Улсын хэмжээнд олон нийтийн мэдээлэл харилцаа болон хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээг хослуулсан хоёроос доошгүй төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай.
- Төрийн албан хаагчид, хувийн хэвшил, олон нийт зэрэг ялгаатай зорилтот бүлгүүдэд хууль эрх зүйн цогц ойлголтуудыг үр дүнтэй хүргэх чадвартай.

## 4. Уян хатан байдал ба дасан зохицох чадвар:

- Нэмэлт мэргэшсэн туршлага шаардлагатай тохиолдолд олон улсын экспертүүд эсвэл зөвлөх фирмүүдтэй хамтран ажиллах хүсэл, чадвартай байх.
- Дэлхийн жишгийг дотоодын бодит байдалтай тэнцвэржүүлж, олон улсын шилдэг туршлагыг Монголын нөхцөлд нийцүүлэх чадвартай байх.

Сонгон шалгаруулалтыг Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны **Зөвлөхийн чадварт суурилсан сонгон шалгаруулалтын (Consultant's Qualifications Selection)** аргаар явуулах бөгөөд Дэлхийн банкнаас 2023 оны 09 дүгээр сард баталсан “Худалдан авах ажиллагааны журам” (“Procurement Regulations for IPF Borrowers” September 2023 edition - “Procurement Regulations”) -ын дагуу хэрэгжүүлнэ. Тус журамд заасан эрх бүхий бүх этгээдүүд сонгон шалгаруулалтад оролцох боломжтой.

Нэмэлт мэдээллийг ажлын өдөр 09:00-18:00 цагийн хооронд доорх мэдээллийн дагуу холбогдож авна уу.

Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой зөвлөх байгууллагууд **Төрийн сан дах 101900011844 тоот Ухаалаг засаг-2 төслийн** дансанд **50,000 төгрөг** тушаасан баримтыг [procurement2@smart.gov.mn](mailto:procurement2@smart.gov.mn) имэйл хаягаар ирүүлж баталгаажуулсанаар шалгаруулалтад орох эрхтэй болох бөгөөд сонирхол илэрхийлэх хүсэлтийн материалуудыг цахимаар буюу [procurement2@smart.gov.mn](mailto:procurement2@smart.gov.mn) имэйл хаягаар болон давхар цаасан хэлбэрээр **2024 оны 10 сарын 22-ны 15 цагаас** өмнө ирүүлнэ үү.

### Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Самбуугийн гудамж, Бага тойруу  
Сити капитал оффис, 301 тоот  
Ухаалаг засаг-2 төсөл

Утас: 51261268

И-мэйл: [procurement2@smart.gov.mn](mailto:procurement2@smart.gov.mn)